



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 07 өдөр

Дугаар А103

Улаанбаатар хот

Засаг даргын дэргэдэх “Өсвөрийн
шигшээ баг”-ийн нэрэмжит “Волейбол”-ын нээлттэй
тэмцээн зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Засаг даргын дэргэдэх “Өсвөрийн шигшээ баг”-ийн нэрэмжит “Мини волейбол”-ын U11, U12 тэмцээнийг 2025 оны 01 дүгээр сарын 10, 11, 12-ны өдөр чанар, үр дүнтэй зохион байгуулахыг Биеийн тамир, спортын хороо (Г.Тэмүүлэн)-нд үүрэг болгосугай.

2.Тэмцээн зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр, шаардагдах хөрөнгийн төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Тэмцээн зохион байгуулахад шаардагдах 2.999.600 (Хоёр сая есөн зуун ерэн ес зургаан зуу) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.


4.Санхүүгийн тайланг 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Засаг даргын Тамгын газарт ирүүлэхийг Биеийн тамир, спортын хороо (Г.Тэмүүлэн)-нд, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Нийгмийн хөгжлийн хэлтэс (Б.Цогжавхлан)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 01 сарын 07-ны өдрийн 103 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
“ӨСВӨРИЙН ШИГШЭЭ БАГ”-ИЙН НЭРЭМЖИТ МИНИ ВОЛЕЙБОЛЫН
U11, U12 НАСНЫ АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ**

Нэг. Тэмцээний зорилго

Дүүрэгт “Мини волейбол”-ын спортыг сурталчлан түгээн дэлгэрүүлэх, Өсвөрийн шигшээ багийн хүүхдүүдийн ур чадварыг сайжруулах, волейболын спортыг сонирхогчдын тоог нэмэгдүүлэхэд тэмцээний зорилго оршино.

Хоёр. Ерөнхий мэдээлэл, зохион байгуулалт

Зохион байгуулагч: Багахангай дүүргийн Биеийн тамир, спортын хороо
“Тэмүүлэл” Клуб
Засаг даргын дэргэдэх “Өсвөрийн шигшээ баг”

Зохион байгуулах газар: Нийслэлийн Багахангай дүүрэг, Биеийн тамир, спортын хороо (УБ хотоос 90км)

Зохион байгуулах хугацаа: 2025 оны 01 дүгээр сарын 10-12-ны өдрийн хооронд зохион байгуулагдана.

Техникийн зөвлөгөөн: 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 19:30 цагаас цахимаар (zoom) зохион байгуулагдана.

Гурав. Тэмцээний бүртгэл

Бүртгүүлэх материал:

1. Гадаад паспорт хүүхдийн насыг зөвхөн гадаад паспортыг үндэслэж тогтооно. Гадаад паспорт байхгүй тамирчныг тэмцээнд оролцуулахгүй.
2. Багийн мэдүүлэг: 2024 оны 01 дүгээр сарын 07-ны 17:00 цагаас өмнө [/harzag.altai@gmail.com](mailto:harzag.altai@gmail.com) хэлбэрээр явуулж, бүртгэлийн эрхийн хураамж 200.000 төгрөгийг 300700037852 (Төрийн банк) Мөнхтулга дансанд хийснээр бүртгэл баталгаажна. Гүйлгээний утга дээр багийн нэр дасгалжуулагчийн нэр утасны дугаар заавал бичнэ.
3. Багийн тоо хязгаартай:
U11 эрэгтэй 20, U11 эмэгтэй 20 баг (2014 оны 01 сарын 01-12-31-ны хооронд төрсөн хүүхэд, багачууд)
U12 эрэгтэй 20, U12 эмэгтэй 20 баг (2013 оны 01 сарын 01-12-31-ны өдрийн хооронд төрсөн хүүхэд багачууд)
Багууд нийт 5 тоглогчийн бүрэлдэхүүнтэй байна.

Дөрөв: Шагнал урамшуулал

- **Тэргүүн байр:** Медаль, Өргөмжлөл, Мөнгөн шагнал
- **Дэд байр:** Медаль, Өргөмжлөл, Мөнгөн шагнал
- **Гутгаар байр:** Медаль, Өргөмжлөл, Мөнгөн шагнал
- **Өсөх ирээдүйтэй тамирчин:** U11, U12 эрэгтэй, эмэгтэй тус бүр 1 тамирчин


Долоо: Тоглолтын дүрэм журам

1. Тоглолт 3 ээлжээр 15 оноогоор явагдана.
2. Тоглолтын хувцас, хувийн дугаартай байна.
3. Багууд хуваарийн дагуу цаг баримталж оролцох.
4. Багууд тоглолтын хуваарийн дагуу оролцох ба 5 минут хүлээлгээд ирээгүй тохиолдолд хожигдол хүлээх болно.

Найм: Анхаарах зүйл

1. Багш дасгалжуулагч нар багийн хүүхдүүдийн аюулгүй байдлыг хангах
2. Зам тээвэр, хүнсний эрүүл ахуйг мөрдөх, хангах
3. Үе тэнгийн дээрэлхэлтээс сэргийлэх
4. Хараа хяналтыг сайжруулах
5. Байрласан байрныхаа эд хогшил, техник хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангах
6. Тэмцээн зохион байгуулагдах Спорт заал болон байрлах байрнаас гадуур аливаа эрсдэлд өртсөн тохиолдолд Зохион байгуулагч тал хариуцахгүй болно.

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 01 сарын 07-ны өдрийн 1103 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт



ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
“ӨСВӨРИЙН ШИГШЭЭ БАГ”-ИЙН НЭРЭМЖИТ МИНИ
“ВОЛЕЙБОЛ”-ЫН ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛАХАД
ШААРДЛАГАТАЙ ТӨСӨВ

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг Бүрийн үнэ	Нийт үнэ
1	1-р байр Алтан медаль (2 насны ангилал)	ш	24	16.000	384.000
2	2-р байр Мөнгөн медаль (2 насны ангилал)	ш	24	16.000	384.000
3	3-р байр Хүрэл медаль (2 насны ангилал)	ш	24	16.000	384.000
4	Өргөмжлөл	ш	12	45.000	540.000
5	Өсөх Ирээдүйтэй тамирчин	ш	8	50.000	400.000
6	Аннос	м2	11,8	22,000	259.600
7	Бөмбөг	ш	2	324.000	648.000
	Нийт зардал				2.999.600